

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл

Мэдээллийн эмхэтгэл No.31

Монголд анх удаа DET Трэйнер бэлтгэх тухай (2019.10.31)



Трэйнерийн сургалтын оролцогчид

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Трэйнер гэж хэн бэ? DET Сургагч багшаас юугаараа ялгаатай вэ? Сургагч багш нь DET сургалтыг явуулдаг бол Трэйнер нь тэдгээр сургагч багш нарыг бэлтгэх багш юм. DET сургалт нь дэлхийн 40 оронд явагдаж буй бөгөөд нийт 500 сургагч багш бий. Харин трэйнерийн хувьд дэлхийд ердөө л 6 хүн байгаагийн 2 нь Японд, 4 нь Малайзад байдаг. DPUB төслийн зүгээс Монголд анх удаа DET трэйнер бэлтгэх зорилгоор сургалт явуулж байна. Сургагч багш нар дотроос хамгийн идэвхтэй ажиллаж буй 3 хүн тус сургалтад хамрагдаж байгаа юм. Тэд 6 долоо хоногийн, нийт 60 цагийн шахуу хөтөлбөртэй сургалтанд оролцож байна.

“Энэ хөтөлбөр дууссаны дараа 12-р сард зохион байгуулагдах Сургагч багш бэлтгэх сургалтыг бид 3 удирдан явуулах болно. Өнөөг хүртэл тус сургалтыг япон мэргэжилтэн зааж ирсэн. Бага зэрэг санаа зовж буй боловч сургалт болтол бэлтгэлээ бүрэн дүүрэн хангах болно!” хэмээн ярих оролцогчид гэрийн даалгавар, дасгал ажил гээд ачаалал ихтэй байгаа хэдий ч зорилгодоо хүрэхийн тулд хичээн суралцаж байна. Бүгдэд нь амжилт хүсье!



Хигашида мэргэжилтэн
леки уншиж

Халамжийн үйлчилгээний тогтолцоо болон хэрэгжилт (2019.11.14)

10-р сарын 23-ны өдөр Хөгжлийн бэрхшээлийн 4 дэх цуврал сургалтын 2 дахь удаагийн хичээл болж өнгөрлөө. Сургалтын эхэнд Монгол Улс дахь Нийгмийн халамжийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын талаар оролцогчдын саналыг сонсов. Монгол Улсад хууль дүрэм, тогтолцоо байдаг ч бодит байдал дээрх хэрэгжилт ихэнхдээ хангалтгүй байдаг гэсэн санал гарч байлаа. Тиймээс нэн тэргүүнд хэрэгжилтийн тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгаа юм. Үүний дараа Япон улсын хөгжлийн бэрхшээлийн салбар дахь нийгмийн халамжийн үйлчилгээний талаар тайлбарлаж, халамжийн үйлчилгээний тогтолцооны

хөгжил дэвшлийн түүхэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо, тэдэнтэй хамтарч хэрэгжүүлсэн сайн дурын үйл ажиллагаанууд салшгүй холбоотой байдаг талаар жишээ татан танилцууллаа. Мөн Японы нийгмийн халамжийн тогтолцоонд ч засаж сайжруулах асуудлууд цөөнгүй бөгөөд төрийн бодлого, тогтолцоог сайжруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолой маш чухал байдаг талаар санууллаа. Харамсалтай нь энэ удаагийн сургалтад оролцогчдын тоо бага байсан. Дараа дараагийн сургалтад илүү олон хүмүүс оролцох байх аа гэдэгт итгэлтэй байна. Дараагийн сургалтын зарыг тусад нь хүргэх болно.

**JICA DPUB фэйсбүүк
хуудсанд LIKE дарж
нэгдээрэй!!**



[https://www.facebook.com/
jicadpub/](https://www.facebook.com/jicadpub/)

Төслийн фэйсбүүк хуудсанд **LIKE** дарсан нийт хүний тоо **5864** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэх болно.

Хөгжлийн бэрхшээлийн тухай цуврал сургалт (2019.11.13)

Мэргэжлийн ангийнхны 9 дэх удаагийн хичээл амжилттай болж өнгөрлөө. Энэ удаагийн хичээлд 12 оролцогч хамрагдсан бөгөөд илтгэл тавьсан оролцогчдын дундаас Сумъяахүүгийн “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөн” сэдвээр бэлтгэж ирсэн илтгэл маш үр өгөөжтэй байв. 2003 онд харааны бэрхшээлтэй иргэд өлсгөлөн зарласан тухай, 2005 онд Нийгмийн халамжийн хуулийг эсэргүүцсэн үйл ажиллагаа өрнүүлж байсан гэх мэтээр Монголд ч гэсэн 2000-аад оны эхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн хөдөлгөөн өрнүүлж байсан талаар ойлголттой болж чадлаа. Сумъяахүү тус илтгэлийн материалаа бэлтгэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч олон хүмүүстэй яриа хийсэн гэж байсан. Энэ мэтээр холбогдох мэдээллүүдийг хүчин чармайлт гарган цуглуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөний түүхийг нэгтгэж чадах юм бол цуврал сургалтуудын томоохон үр дүн болох юм гэж бодлоо. Сонирхолтой илтгэл тавьсан Сумъяахүүдээ талархал илэрхийлье.



Сумъяахүү (зүүн тал)

Хүний эрхийн үндэсний комисс дахь лекц (2019.11.15)

Хүний эрхийн үндэсний комиссын урилгаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, дэд бүтцийн хүртээмжийн талаар лекц уншсан бөгөөд 30 орчим хүн хамрагдлаа. Лекцэнд зориулж гоёмсог панел танилцуулга хүртэл хэвлүүлсэн байсан учраас урам зоригтойгоор илтгэлээ тавив. Дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байгаа талаар Улаанбаатар хотын иргэн бүр мэдэж байгаа боловч хэрхэн сайжруулах арга нь олонд танигдаагүй, хэт огцом налуу зам яагаад ийм их байгаа талаар мэдэхгүй хүмүүс олон байх аа гэж бодож байна. Иймд дэд бүтцийг сайжруулснаар өндөр настан, жирэмсэн эхчүүд гээд бүх хүн амьдрахад таатай хотыг бий болгох, барилгын хяналтын тогтолцоог сайжруулахгүй бол огцом



Дургалын зураг татүүлал

налуу замууд цаашид ч байсаар байхыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн үүднээс тайлбарлав. Энэ удаагийн лекц сонирхолтой, үр өгөөжтэй байсан гэдэгт итгэлтэй байна.

Япон санд ажилд орж, өргөдөл хүсэлт хариуцах болсон нь



Ахлах зөвлөх Чибя Хисао

2007 оны 9-р сард Япон сангийн Олон улсын хамтын ажиллагааны группт ажилд орлоо. Тэгээд Азийн хөгжиж буй орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үйл ажиллагааг хариуцах болсон. ЖАЙКА-д байхдаа төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хариуцдаг байсан боловч Япон санд санхүүжилтийн мөнгө олгох ажлыг хариуцдаг болов. Өөрөөр хэлбэл сайн төсөл, үйл ажиллагаанд санхүүжилт олгох ажил юм. Энэ ажлаас ч би их зүйл сурсан. Маш олон төрлийн өргөдөл хүсэлттэй танилцдаг учраас байгууллага тус бүр санхүүжилт авахын тулд ямар төсөл, үйл ажиллагаа санаачлах нь сонирхолтойн дээр юм сурч мэдэх сонирхлыг төрүүлдэг байв. Гэхдээ тодорхойгүй өргөдөл хүсэлтүүд ч нэлээдгүй ирдгийг анзаарсан. Сайн төлөвлөгөө хэдий ч бичсэн агуулга нь тодорхойгүй юм уу, эсвэл угаасаа сонин төлөвлөгөө болохоор өргөдөл нь уншихад ойлгомжгүй ч юм уу... Харин сайн өргөдөл бол уншихад ч хялбар, их зүйлийг сурч мэдэж авдаг гэдгийг ойлгосон. Үнэхээр сайн бичсэн хүсэлтийг уншсаны дараа өөрөө ч толгой сайтай болсон юм шиг санагддаг. Энэ туршлага маань дараа нь санхүүжилт олгох хүсэлт бичихэд маш их тус болсон.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com